



# ЭКСПО МОНГОЛИА

УУЛ УУРХАЙ БОЛОН БУСАД САЛБАРЫН  
ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН ОЛОН УЛСЫН  
ХУРАЛ, ҮЗЭСГЭЛЭН



## Монгол улсын ирээдүйн төлөө

2016 оны 5 сарын  
23-25 ны өдрүүдэд  
Буянт-Ухаа Спортын Ордонд





“Экспо Монголиа 2015” үзэсгэлэнгийн үйл ажиллагаа нь Германы 30 гаруй байгууллага, Монгол улстай бизнесийн холбоо харилцаагаа тогтоон, цаашлаад хамтын ажиллагаагаа улам гүнзгийрүүлэн хөгжүүлэхэд чиглэгдсэн томоохон хэмжээний холбох гүүр болж чадсан. Монгол, Герман хоёр улсын урт хугацааны харилцан хамтын ажиллагааны түншлэлийн хүрээнд энэхүү үзэсгэлэн нь Герман улсын экспортлогчдын хувьд өндөр үр ашиг бүхий үйл ажиллагаа боллоо. Бид дараагийн “Экспо Монголиа” үзэсгэлэнгийн үйл ажиллагааг тэсэн ядан хүлээж байна. «

МОНИКА ХОЛЛАХА, ГЕРМАН ИНЖЕНЕРИЙН ХОЛБОО

## Монгол Улс цаашид өсөн дэвжих өндөр ирээдүйтэй орон

Монгол улсын эдийн засгийн гол хөдөлгүүр, хүчин зүйлийг уул уурхайн салбар гэж гадаадын улс орнууд төдийгүй Монгол улс өөрөө ч хүлээн зөвшөөрдөг. Газар доорх арвин их нөөцтэй тус улсын эдийн засгийн гол хөшүүрэг нь нүүрс, газрын тос, алт, мөнгө, зэс зэрэг ашигт малтмалыг олборлох явдал мөн хэмээн үзэж анхаарлаа энэ зүгт хандуулан ажиллаж байна. Монгол улс нь Таван Толгой, Оюу Толгой (ОТ) гэх мэт уурхайнуудын үйл ажиллагааны үр дүнд, уул уурхайн салбарт манлайлагч, томоохон хэмжээний үйлдвэрлэгч орон болох асар их боломж бий.

Оюу толгой төслийн хүрээнд шинэ гэрээг үзэглэснээр, уул уурхайн хөгжлийн эхний алхам хийгдсэн гэж үзэж байна. Харин дэлхийн зах зээлд өөрсдийн нөөц баялагаа гаргах, улс орондоо арвин их үр ашгийг авчрах, түүнчлэн энэ чиглэлийн үйл ажиллагааг улам боловсронгуй болгож өндөр хэмжээнд авчрахын тулд, дэд бүтцийнхээ хөгжлийн асуудлыг анхаарч, нэн даруй шийдвэрлэх ёстой.

Монгол улсын нэн тэргүүний зорилго нь, өөрийн орны эдийн засгийн хөгжлийн үр ашиг болон хүрээгээ өргөжүүлэн тэлж, уул уурхайн салбар бүрийн цаашдын хөгжилд гол анхаарлаа чиглүүлэн ажиллах явдал юм.

**Монгол улсын ирээдүйн хөгжил дэвшилд хувь нэмрээ оруулж, тус улсад шинээр бизнес эхлүүлэх болон хамтран ажиллахад гадаадын хөрөнгө оруулагчдад, холбоо болон хувийн аж ахуйн нэгжүүдэд хамгийн тохиромжтой цаг үе юм.**

### Эрчим хүч

- Монгол улсын газрын тосны нөөц баялгийг, ойролцоогоор 4-өөс 6 тэрбум баррель гэж тооцсон байна. Тус улсын засгийн газар ирэх жилээс эхлэн газрын тосны олборлолтыг нэмэгдүүлэх, цаашид эрчимжүүлэх тал дээр гол анхаарлаа хандуулах зорилт тавин ажиллах болно.
- Монгол улс нь сэргээгдэх эрчим хүчний салбарт дунджаар, жилдээ 1400 кВт.ц өдөртөө нэг квадрат метр тутамд 4.3 - 4.7 кВт.ц хэмжээний нарны эрчим хүч тус тус гарган авах чадвартай гэж Эрчим Хүчний Яамнаас мэдээлсэн байна.
- Дэлхийн эрчим хүчний төв байгууллагын мэдээлснээр, Монгол улс нь нүүрснийхээ салбараас хэт их харьяалалтай байгаа бөгөөд дэлхийд эрчим хүчнээс хамгийн их хамааралтай орнуудын жагсаалтад арав дугаарт, хамгийн их нүүрс хэрэглэдэг орнуудын жагсаалтад тав дугаарт багтах эдийн засгийн хөгжилтэй орон гэж эрэмбэлэгдсэн байна.

### Хөдөө аж ахуй

- 2014 оны судалгаагаар Монгол улсын хөдөө аж ахуйн салбар нь ДНБ-ний 20 гаруй хувийг хамардаг бөгөөд, нийт ажиллах хүчний 40 гаруй хувийг эзэлж байсан.
- Монгол улс нь мянга мянган га бүхий өргөн уудам газар нутагтай, нүүдлийн мал аж ахуй эрхлэх арвин их туршлагатай орон бөгөөд тус улс нь олон жилийн туршид хөдөө аж ахуйн салбарын хөгжилдөө түлхүү анхаарсаар ирсэн. Гэсэн хэдий ч хөдөө аж ахуйн салбарт шинэ дэвшилтэт технологи нэвтрүүлэх, түүнчлэн цаашдын тогтвортой хөгжлийн асуудал нь тус орны хувьд бага хэмжээний байр суурь эзэлж байсан. Тиймээс хөдөө аж ахуй, газар тариалангийн салбарт машин механизм, тоног төхөөрөмж нийлүүлэх нь экспортлогч борлуулагчдын хувьд бизнесээ өргөжүүлэхэд томоохон боломж, үүд хаалгыг нээж өгч байна.

### Уул уурхай

- Таван Толгой ХХК нь ойролцоогоор 7,42 тэрбум тонн нүүрсний нөөцтэй бөгөөд түүхий кокс, түлшний нүүрсний ордоороо дэлхийд хамгийн томд тооцогддог.
- Оюу Толгой ХХК-ийн олборлоогүй зэсийн орд (ойролцоогоор 3.8 тэрбум тонн зэсийн нөөцтэй нь батлагдсан) болон алтны уурхайн орд газар нь (ойролцоогоор 3.9 сая унц алтны нөөцтэй), Монгол улсыг дэлхийд томоохон хэмжээний нөөцтэйг батлан харуулж байна. Монгол Улсын Засгийн газрын 2015 оны гэрээний шийдвэр нь Монгол улсын эдийн засгийн хөгжилд нэн чухал ач холбогдолыг авчирсан бөгөөд энэ салбарын тулгын чулуу болсон юм.

### Барилга, Хот байгуулалт, Дэд бүтэц

- Монгол Улсын хүн амын хотжилт тасралтгүй өсөн нэмэгдэхийн хэрээр, барилга байгууламжийн үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх, тэдгээрийг цаашид тогтвортой хөгжүүлэх шаардлага урган гарч байна. Тус улсын барилгын салбарын өсөлт 2014 оны ДНБ-ний өсөлтийн 10 гаруй хувийг эзэлж байна. Түүнчлэн Монгол улсын тээврийн салбар, олон нийтийн үйлчилгээний сүлжээг өргөтгөх, шинэчлэх асуудал нь төр засгийн анхаарлын төвд байгаа. Монгол Улсын Засгийн Газар төмөр замын сүлжээ, хот доторх тээвэрлэлтийн систем, зам угсралтын ажлыг цаашид хөгжүүлэх, шинэчлэх талаар анхаарч, хөрөнгө оруулалтаа нэмэгдүүлж байна.





## “Экспо Монголиа” үзэсгэлэнгийн тухай

“Экспо Монголиа” нь үйлдвэр аж ахуйн нэгжүүд харилцан бизнесийн холбоо тогтоох, Монгол улсад болон ойр орчмын улс орнуудын мэргэжил нэгтнүүдэд өөрийн үйлдвэрлэл үйлчилгээний шинэ шинэлэг технологиудынхаа талаар танилцуулах, борлуулахад зориулагдсан олон улсын өндөр зэрэглэлийн үзэсгэлэн юм.

“Экспо Монголиа” нь Германы Эдийн Засаг, хамтын ажиллагааны яам, Германы хүнд хөнгөн машин механизм үйлдвэрлэгчдийн холбоо, Чех улсын Худалдааны Танхим, үйлдвэр аж ахуйн нэгжүүд, холбоод болон хэвлэл мэдээллийнхний дэмжлэг туслалцааг авч хамтран ажилладаг билээ.

“Экспо Монголиа” нь үзэсгэлэн зохион байгуулахын зэрэгцээ зах зээлийн хөгжил дэвшил, том хэмжээний төсөл, хөрөнгө оруулалтын боломжийн талаар өндөр хэмжээний хурал зөвлөгөөнийг зохион байгуулдаг. Үзэсгэлэнд оролцогчид үзэсгэлэн болж буй тухайн газарт, нөлөө бүхий үйлчлүүлэгчидтэй урьдчилан тусгай уулзалт товлон уулзах боломжтой.

**“Экспо Монголиа” – 2016 бизнес эрхлэгчдийн заавал байх ёстой газар**



Үзэсгэлэнгийн үеэр би Монголын зах зээлийн талаар бүрэн дүүрэн мэдээллийг олж авсан бөгөөд тэнд чулуулгийн бизнес эрхлэгчид бүгдээрээ байсан! Энэ бол таны заавал оролцох ёстой газар юм. «

ХУДАЛДААНЫ МЕНЕЖЕР ЖУАННИ БЕНАТТИ, ИТАЛИЙН БРЕТОН КОМПАНИ



БНПАУ-ын Эдийн Засгийн Яамнаас санаачилсан “Польшид үйлдвэрлэв - Монгол улсын компаниудын хамтын ажиллагааны боломж” нэртэй хурал нь 2015 оны гуравдугаар сард манай яам болон зохион байгуулагчид бид Экспо Монголиатай хамтран маш амжилттай зохион байгуулагдаж үр дүнд хүрсэндээ туйлын баяртай байна.

Иймээс Экспо Монголиа нь бүхий л дотоод, гадаадын үйлдвэрлэгчид, бизнесменүүд, мөн түүнчлэн гадаадын байгууллагууд, Монгол улстай бизнесийн харилцаагаа өргөжүүлэхэд хамгийн зөв газар нь болж өгөх юм. «

МАРТИНА МАЕВСКА, “М ПРОМОУШИОН АГЕНТ”, ПОЛЬШ УЛС

## “Экспо Монголиа” танд дараах боломжуудыг санал болгож байна

- **Өндөр зэрэглэлийн зочдын бүрэлдэхүүн** Төр, Засгийн газар, үйлдвэрлэлийн байгууллагууд, хувийн хэвшлийн Аж Ахуйн Нэгжүүдийн чадвар чансаа бүхий өндөр мэргэжилтэн, үйлчлүүлэгчидтэй уулзаж бизнесийн хамтын ажиллагаагаа өргөжүүлэн, гэрээ хэлэлцээр тогтоох.
- **Орон орны үзэсгэлэнгийн талбай болон бие даан нэгдэж буй өргөн цар хүрээ бүхий олон улсын үзэсгэлэнд оролцогчид** Монгол улсад зохион байгуулагдаж буй цорын ганц олон улсын стандартын дагуух үзэсгэлэнд бидэнтэй нэгдэж өөрийнхөө компанийг сурталчлах боломж.
- **Хувийн харилцаа холбоо, яриа хэлэлцээрийг газар дээр нь хийх боломж** Өрсөлдөгч байгууллагууд болон зорилтот зах зээлтэй холбоо тогтоох, түүнчлэн найдвартай үйлчлүүлэгчдийг олж авах.
- **Үзэсгэлэнгийн зэрэгцээ дотоод гадаадын илтгэгч, түншүүдийг хамарсан өндөр зэрэглэлийн семинар, хурал зөвлөгөөний хөтөлбөрүүд** Зах зээлийн шинэ шинэлэг санаа, технологийн дэвшилтэт хөгжилтэй танилцаж, хөрөнгө оруулалтын боломжийг судлах, ирээдүйд хийхээр зорьж буй төслүүд дээр мэдээлэл цуглуулах, түүнчлэн зорилтот зах зээлд өөрсдийн хийсэн шинэ техник, технологи, шинэчлэлтийг танилцуулах өргөн боломж.
- **Таны өндөр зэрэглэлийн шаардлагад төгс нийцсэн, сайн чанар бүхий үзэмжтэй, загварлаг үзэсгэлэнгийн талбай** Бүрэн тохижуулсан үзэсгэлэнгийн талбайн багц, өөрсдөө тохижуулах багц эсвэл энгийн загвар бүхий багцуудаас та сонголтоо хийж болно.



# Экспо Монголиа 2015 товч тайлан

- Уг үзэсгэлэнд Австри, Чех, Герман, Итали, Монгол, Орос зэрэг нийт 10 улс орноос оролцсон.
- Монгол болон олон улсын дипломат төлөөлөгчид, төр засгийн сайдууд болон нийгэмлэг холбоодын тэргүүнүүд зэрэг хүндтэй зочид төлөөлөгчид хүрэлцэн ирсэн.
- Гурван өдрийн хурал зөвлөгөөнд: Хөрөнгө оруулалтын боломж бололцоо, улс орны хүрээнд хэрэгжих төсөл, зах зээлийн хөгжил зэрэг чухал сэдвүүдийг авч хэлэлцсэн.
- Үзэсгэлэнгийн хүрээнд багтсан үйл ажиллагааны цар хүрээнд нийт оролцогчдын 100 % нь үнэлгээ өгсөн бөгөөд үүний 43 % нь маш сайн, 48 % нь сайн, 9 % нь боломжийн хэмээн дүгнэсэн байна.
- “Экспо Монголиа” 2015 үзэсгэлэнд оролцогчидтой бизнесийн хамтрагч болон ажиллахаа нийт оролцогчдийн 85 % төлөвлөсөн.



“Экспо Монголиа” нь Монгол Улсын болон Олон улсын бизнесийн хөгжилд гайхалтай хувь нэмрээ оруулахуйц үзэсгэлэн юм. Монгол улсын үйлдвэрлэлийг цаашид хөгжүүлэх өндөр боломжийг олгож буй тус үзэсгэлэн нь мэргэжлийн өндөр түвшинд зохион байгуулагддагаараа онцлог бөгөөд 2016 оны таван сард зохион байгуулагдах дараагийн үзэсгэлэнг бид тэсэн ядан хүлээж байна. «

КАРСТЕН КЕОПКЭ “НЬУ ТАЙМС ТЕХНОЛОЖИС” ХХК

## “Экспо Монголиа” 2016 – Ирээдүйн зорилго:


- Олон улсын үзэсгэлэнгийн талбайнуудыг багтаасан Ази, Европ, Америк, Дундаж Азийг хамарсан нийт 100 гаруй Олон Улсын үзэсгэлэнд оролцогчид
- Хурал зөвлөгөөн: Зах Зээлийн боломж, ирээдүйд хэрэгжүүлэх төслүүдийн талаарх илтгэл, шинэ техник технологио танилцуулах дотоод гадаадын илтгэгчдийн илтгэл болон дугуй ширээний зөвлөгөөн, семинар, сургалт зохион байгуулах
- Таны компанийн талаар Олон Улсын бизнесийн түншүүд болон оролцогчдод төгс мэдээлэл өгч, өөрийн компанийг танилцуулахад зориулсан чанартай, загварлаг талбайн багцууд мөн хурлын танхимд тусгайлан бэлдсэн дэлгэцэн дээр танилцуулах боломж
- Холбогч гүүр: Зөвхөн үзэсгэлэнд оролцогчидод зориулсан урьдчилан сонгосон хэрэглэгчидтэйгээ уулзах боломжийг олгох зохион байгуулалттай уулзалт




# 2015 оны үзэсгэлэнд оролцогчдын санал хүсэлт

Таны үндсэн маркетингийн санаа болон үзэсгэлэнд оролцох болсон шалтгаан тань юу вэ? Уг санаагаа та хэрхэн дүгнэх вэ?


Шинэ худалдааны чиглэл үүсгэх




Шинэ бүтээгдэхүүн гаргах




Үйлчлүүлэгчидтэй уулзах



Та зорилтот үйлчлүүлэгчдэд хэрхэн үнэлгээ өгөх вэ?



■ Маш сайн   
 ■ Сайн   
 ■ Боломжийн   
 ■ Муу



## Экспо Монголиа үзэсгэлэнд оролцох салбарууд:

### БАРИЛГА, БАЙГУУЛАМЖ

- Барилгын материал, тоног төхөөрөмж
- Барилгын машин, тээврийн хэрэгсэл
- Техник хангамж, төхөөрөмжүүд

### УУЛ УУРХАЙ

- Машин, тоног төхөөрөмж
- Түхийн эдийн тээвэрлэлт
- Ашигт малтмалын боловсруулалт

### НҮҮРС, БАЙГАЛИЙН НӨӨЦ БАЯЛАГ

- Үйлдвэрлэл, Боловсруулалт, Тоног төхөөрөмж
- Инженерийн ажил, Загварын ажил, Зураглалын ажил, Зөвлөгөөн
- Программ хангамж

### ДЭД БҮТЭЦ

- Зам тээвэр, Тэмдэглэгээ, Замын хөдөлгөөний систем
- Нийтийн тээвэр, Терминалууд
- Зар сурталчилгааны хөгжил, үйлдвэрлэл, Үйлдвэрлэлийн бүсүүд
- Хотын загвар, Төлөвлөгөө, Орчны тохижилт

### БАЙГАЛЬ ОРЧНЫ ТЕХНОЛОГИ, ХОТЫН ТОНОГ ТӨХӨӨРӨМЖ

- Ус болон Хаягдал усны цэвэршүүлэлт
- Агаарын бохирдлын хяналт болон Ариутгал
- Гудамжны цэвэрлэгээ, Засвар, Өвлийн замын үйлчилгээ

### ТУСЛАХ ЭРЧИМ ХҮЧ, ЦАХИЛГААН

- Нарны эрчим хүч
- Геотүлш
- Био-Энерги

### ЭМНЭЛЭГ, ЭРҮҮЛ МЭНДИЙН ХАНГАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭ

- Эмнэлгийн тоног төхөөрөмж, үйлчилгээ
- Ерөнхий мэс засал
- Эрүүл амьдралын хэв маяг, Эрүүл ахуйн болон сувилалын бүтээгдэхүүнүүд

### ХӨДӨӨ АЖ АХУЙ, ОЙЖУУЛАЛТ

- Хөдөө Аж Ахуйн механизм, сэлбэг, үйлчилгээ
- Газар тариалан, Үр суулгах, Бордох, Усжуулалт, Хатаах
- Мал аж ахуй

### ХООЛ ХҮНС, БОЛОВСРУУЛАЛТ

- Хоол хүнс, Шингэн зүйлсийг боловсруулагч тоног төхөөрөмж
- Хоол хүнсний үйлчилгээний төхөөрөмжүүд
- Хөлдөөх, Хадгалах систем
- Сав баглаа боодол

### ТЭЭВЭРЛЭЛТ БОЛОН ЛОГИСТИК

- Ачаа ачилт, Тээвэрлэлт, Логистикийн үйлчилгээ
- Интра-Логистик, Агуулахын систем, Машины мэдээлэл
- Алсаас удирдах холбоо, e-Бизнес, Харилцаа холбоо

### АЖ ҮЙЛДВЭР, ҮЙЛДВЭРЛЭЛ, ТОГ ЦАХИЛГААН

- Автоматжуулалт, Хөдөлгүүр, Мотор, Роботууд
- Машин төхөөрөмж, үйлдвэрлэлийн системүүд
- Шахуурга, хаалтууд
- Цахилгааны эд анги

### МЭДЭЭЛЭЛ, ХАРИЛЦАА ХОЛБООНЫ ТЕХНОЛОГИ

- Зөөвөрлөгч, Сүлжээ болон Харилцаа холбооны үйлчилгээ
- Хадгалалт, Өгөгдөл, Аюулгүй байдлын үйлчилгээ
- Үүрэн телефон, Утасгүй интернетийн холболт

### БАНК, САНХҮҮ

### СУДАЛГАА, БОЛОВСРОЛ, НИЙГМИЙН ҮЙЛЧИЛГЭЭ

### РЕДАКЦУУД, МЭДЭЭЛЭЛ, ХЭВЛЭХ ҮЙЛДВЭРЛЭЛТ

Дэлгэрэнгүй мэдээллийг:

→ [www.expomongolia.com](http://www.expomongolia.com)



Хамтрагч болон дэмжигч байгууллагууд: “Экспо Монголиа” нь төрийн байгууллагууд, үйлдвэрлэл аж ахуйн нэгжүүд, олон улсын холбоо болон хэвлэл мэдээллийнхний туслалцааг авч ажилладаг бөгөөд энэ нь манай хамт олны хувьд нэр хүндийн хэрэг юм. Үүнд:



болон бусад байгууллагууд

Дэлгэрэнгүй мэдээллийг:

[www.expomongolia.com](http://www.expomongolia.com)



## Холбоо барих хаяг

### МОНГОЛ ДАХ ХАЯГ:



**“ЁОТ ФАУ КОНСАЛТ” ХХК**  
Хатагтай Дамбадорж Нарангиймаа  
Экспресс Цамхаг, 15 давхар  
Энхтайвны Өргөн Чөлөө,  
Улаанбаатар хот 15160, Монгол улс  
Оффис: +976 70009471  
Гар утас: +976 94009471  
+976 88064242  
em@expomongolia.com  
www.expomongolia.com

### ОЛОН УЛСАД:



**Экспо Монголиа 21**  
Лиза Мойллер  
Яаррес гудамж 42  
22303 Хамбург хот, ХБНГУ  
Утас: +49 40 710070-32  
Факс: +49 40 710070-39  
lisa.moeller@planetfair.de  
www.planetfair.de

